



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/375

Улаанбаатар хот

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангаж, хяналт тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4 “д”, 29.1.6 “а, л”, 29.2, 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Агаарын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Сууц өмчлөгчдийн холбоодын эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, 2020 оны 189 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/382 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Дүүргийн 2021-2022 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд дараах арга хэмжээг 2020 оны 08 дугаар сарын 15-наас 09 дүгээр сарын 15-ныг хүртэлх хугацаанд хэрэгжүүлэхийг хороодын Засаг дарга нар, харьяа байгууллагын удирдах албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

2.1. Сайжруулсан шахмал түлшний агуулах, дундын болон хангамжийн бааз, борлуулалтын цэгүүдийн түлш нөөцлөлтийг сайжруулах, тээвэрлэлтийн үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, гэр хорооллын айл өрхийн сайжруулсан түлшний хэрэглээг жигд хүртээмжтэй хангах, сайн картны худалдан авалтад хяналт тавьж ажиллахыг хороодын Засаг дарга нарт;

2.2. Гэр хорооллын айл өрхийн ахуйн хэрэглээний зуухны MNS5216:2016 стандартыг хангуулах, зөв галлагааны зөвлөмж өгөх, зуухны битүүмжлэлийг шалгах, гэр, байшин сууцны агаар сэлгэлтийг сайжруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, угаарын хийн мэдрэгчийг ашиглах заавар өгч, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөлийг хангуулах, хяналт тавьж ажиллахыг дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, дүүргийн Онцгой байдлын хэлтэст;

2.3. Инженерийн хангамжийн байгууллагууд болон бусад холбогдох газруудын хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай ажлын жагсаалтыг хавсралтаар баталж, 2021 оны батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжих инженерийн шугам сүлжээ, авто зам, тохижилтын ажлын нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжилтэд хяналт тавьж, 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулахыг хороодын Засаг дарга нар болон холбогдох байгууллагын удирдлагуудад;

3. Ажлын хэсгийн нэгдсэн төлөвлөгөө боловсруулан танилцуулахыг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс (Б.Мөнх-Эрдэнэ)-т үүрэг болгосугай .

4. Ажлын хэсгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажиллахыг Хэвлэл мэдээллийн алба (Н.Уянга)-нд даалгасугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн дарга Дэд бүтэц, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төслийн удирдагч (Б.Батбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.БАЯРМӨНХ

Баянзүрх дүүргийн Засаг даргын
2021 оны 07 дугаар сарын 28-ны
өдрийн 135 дугаар захирамжийн
хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Баянзүрх дүүргийн Дэд бүтэц, хот
төлөвлөлтийн асуудал хариуцсан
төслийн удирдагч
Б.Батбаяр

Гишүүд:

Баянзүрх дүүргийн Онцгой
байдлын хэлтсийн орлогч, хошууч
Р.Баянжаргал

Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн
хяналтын хэлтсийн дарга
Д.Цэнд-Очир

Баянзүрх дүүрэг дэх Цагдаагийн
газрын дарга, цагдаагийн дэд
хурандаа
П.Очбадрах

Баянзүрх дүүрэг дэх Замын
цагдаагийн хэлтсийн дарга
Цагдаагийн хурандаа
н.Наранбаатар

Баянзүрх дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Хэвлэл мэдээлийн
албаны дарга
Н.Уянга

Баянзүрх дүүргийн Хороодын
Засаг дарга нар

Сууц өмчлөгчдийн холбоодын
удирдлага

Нарийн бичгийн дарга:

Баянзүрх дүүргийн Засаг даргын
Тамгын газрын Төхижилт, нийтийн
аж ахуйн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч
Б.Мөнх-Эрдэнэ